

НИЙТЛЭЛ, ТЭМДЭГЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ

**БНМАУ-ЫН ТУХАЙ МОНГОЛЧ ЭРДЭМТНИЙ
СЭТГЭГДЭЛ**

(Монгол, Японы хооронд дипломат харилцаа тогтоосны 8 жилийн ойд зориулан Токиод (1980 оны хоёрдугаар сарын 23-нд) «Япон-Монголын нийгэмлэг»-ээс зохиосон «Монголын үдэшлэг»-т оролцсон АНУ-ын Индиан их сургуулийн профессор Хангин Гомбожавын* хэлсэн үг).**

Өнөөдөр би «Монголын үдэшлэг» хэмээх ёслол төгөлдөр үдэшлэгт оролцож, надад маш дотно санагддаг өвөг дээдсийн минь улс болох «БНМАУ»-ын тухай ярих завшаан олгосонд туйлын их баяртай байна.

Япон, Монголын хооронд дипломат харилцаа тогтоосны ойг тэмдэглэх энэхүү үдэшлэг нь миний хувьд, Монгол хүний хувьд, мөн түүнчилэн 40 жилийн тэртээ Японд анх дээд боловсрол олж авсан хүний хувьд туйлын их сэтгэгдэл төрүүлсэн үйл явдал болж байна.

Япон, Монголын хооронд байнгын дипломат харилцаа тогтоосон явдал Азийн болон дэлхийн энх тайванд зохих хувь нэмэр оруулах нь маргаангүй. Япон, Монголын соёлын харилцаа нь монголч эрдэмтдэд маш баярлууштай хэрэг болж байна.

Эрт дээр үеэс уламжлал бүхий японы монголч эрдэмтэд Монголтой эрдэм шинжилгээний талаар харилцаж, монгол судлалын ажлаа улам гүнзгийрүүлэх бололцоотой болсон нь туйлын шохоорхмоор зүйл юм.

Монгол улс бол саяхан болтол хүмүүсийн маш буруугаар ойлгож байсан улсын нэг юм.

Японы ахмад хүмүүс хийгээд эрдэмтдийн чармайлтаар сүүлийн үед монголын талаархи японы ойлголт нь нилээд урагшилж, өрнөдийн гүрнүүдээс илүү дэвшсэн гэж үзэж байна.

Хэдий тийм боловч Монголын тухай мэдээлэл нь Японд ч гэсэн өрнөдийн гүрнүүдэд ч гэсэн үзэл суртал, улс төрийн систем нь харилцан адилгүйгээс болж өөр өөрөөр үздэгийн дээр тэдгээрийн тайлбар нь ч тухайн улс орныхоо нөлөөнөөс болж өөр байдаг байх гэж бодно. Ялангуяа хэл бичгийг нь чөлөөтэй эзэмшээгүйн дээр соёлын талаар өөр байгаа ээ- рэг шалтгаанаас болж нэгэн улс ба тэр улсын ард түмний үнэн байдлыг зөв ойлгоход багагүй нөлөөлдөг бололтой.

Тиймээс би: «Монгол улсын гадна байгаа нэгэн монгол хүний нүдээр үзсэн БНМАУ» гэдэг сэдвээр Монголын тухай хувийн сэтгэгдлийг ярихыг хүсч байна.

*Монголч эрдэмтэн Хангин Гомбожав нь АНУ-ын Индиан Их сургуулийн профессор. «Англи-Монгол товч толь», Вейсбаден, 1970. Инжиннашийн «Хөх судрын судалгаа», Гага, 1973; «Дунд шатны ангид үзэх монгол хэл» (орчин үеийн монгол хэлний сурах бичиг). Блюмингтон, Гага, 1976 зэрэг номын зохиогч мөн. Х. Гомбожав нь манай улсад хэд хэдэн удаа ирж ард түмний аж амьдралтай танилцаж байсан юм.

**Найрамдал» Ёкохама. сэтгүүл, 1980, № 3 (Япон хэл дээр.)

Гэвч миний үзэж байгаа ба тайлбарлаж байгаа зүйл нь хөдөлшгүй үнэн гэдэг утга санаа биш нь мэдээж юм. Ялангуяа нэг, хоёр цагийн дотор нэг улсын бүхий л төрхийг танилцуулах нь ч боломжгүй юм. Тиймээс та бүхэнд нэг монгол хүн, Монгол улсыг хэрхэн үзсэн тухайгаа ойлгуулж чадах юм бол туйлын тааламжтай хэрэг билээ.

Би бол өмнөд (Өвөр-орч.). Монголын цахар хүн юм. 1921 онд тухайлбал, Ар Монгол Хятадаас бүрмөсөн салж тусгаар тогтносон тэр онд төрсөн билээ. Миний нутаг болох Тайбус*** хошуу тэр үед Хятадын Цахар мужийн сяниар хүрээлүүлэгдсэн (Цахар мужийг хятадын харьяанд оруулан олон хятад сян нь Тайбус хошууг хүрээлснийг хэлж буй-Орч.) монгол малчдын арал мэт байсан юм.

Миний залуу ахуй цагт өмнөд Монгол нь мөн л эртний феодал, шарын шашны нийгэмд оршиж байлаа. Тэр нь та бүхний ном зохиолоос уншиж байсанчилан монголын ван гүн нарын нийгэм хийгээд шарын шашны хүчтэй нөлөө нь миний хувьд урьд цагийн улсын тухайд биш, миний биеэр амьдарч өнгөрүүлсэн үнэн байдал юм. Тийм ч учраас өвөр монгол хүн болох би өөрийн ах дүү болох Ар Монголтойгоо нэгдэхийн төлөө тэмцэж байсан юм. Монголын тал нутгийн олон олон баатруудын тухай түүх намтрыг дуулсаар өссөн билээ.

Өвөр монголчууд өөрийн билчээр нутгаа алдан, өдөр ирэх тутам түрэмгийлэн ирдэг хятадын тариачид ба худалдаачдын эсрэг баатарлагаар тэмцэж байсан боловч хан (хятад-орч.) үндэстний цэрэг зэвсгийн давуу хүчний өмнө ямар ч боломжгүй байлаа. Тэр үед Хятадын их хуурай газар руу Япон түрэмгийлж байсны улмаас хятадуудын Өмнөд Монгол руу хийж байсан газар нутгийн түрэлт нь нэгэн үед зогссон боловч өвөр монголчууд хятад гэдэг «чононы» амнаас мултарч япон гэдэг «барын» аманд орсон ажээ.

Ийм л цаг үед би тухайн үеийн «Монголын автономит засгийн газар»****-аас Японд илгээсэн оюутны нэг болж 1937 онд Номхон далайн дайн эхэлсэн тэр жилээс 1941 оны эцэс хүртэл Японд сурч байсан юм.

Өвөр монголчууд, Японы ялагдсан тэр үед «олон жил мөрөөдөж байсан Ар Монголын ах дүү нартайгаа нэгдэх боломж ирэв» гэж баярлаж байсан юм.

Гэвч олон улсын гадаад харилцааны шахалтаас болж тэрхүү эрмэлзлэл нь харамсалтайгаар хөсөрдөж билээ.

Тэр үед Өвөр Монголоос олон хүн төрсөн нутгаа орхин зугтаж одсон билээ.

Би бол Америкт монгол хэлбичиг, соёлыг судлах ажлыг олон жил хийж ирлээ. 1961 онд Америкт Монголтой найрамдалт харилцаа тогтоосон цорын ганц «Монголын нийгэмлэг»-ийг байгуулсан хүн байсны хувьд миний бие 1967 онд анх удаагаа БНМАУ-д айлчлах болсон юм. Түүнээс хойш 12 жилийн хооронд 8 удаа Монголд айлчлах таатай боломж надад олдсон билээ.

Зуны амралтаа ашиглан судлал шинжилгээний зорилготойгоор Монголд дунджаар дөрвөн долоо хоног байдаг байлаа. Ялангуяа 1974 онд хамгийн урт 3 сар байсан юм. Би өөрийн мэргэжлийн дагуу Монголын Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиол судлалын хүрээлэн хийгээд Түүх судлалын хүрээлэнгийн эрдэмтэдтэй эрдэм шинжилгээний талаар болон хувийн талаар ч гэсэн найрсаг харилцаагаа гүнзгийрүүлж чадсан юм.

***Цахарын хошуу (Орч.)

****1934—1945 он хуртэл тогтож байсан Өвөр Монголын Дэ вангийн засгийн газрыг хэлж байна. (Ред.)

«БНМАУ-д айлчилсан» явдал бол надад насан турш мөрөөдөж байсан хүсэл минь биелж үнэхээр сэтгэл догдлуулсан хэрэг явдал болсон юм. Юу гэвэл Өвөр Монголд төрсөн, өөрийн улсаа алдсан цөөнх үндэстний золгүй хувь заяагаа үнэн голоосоо сэтгэн, харь улс, харь үндэстний ноёрхлын дор амьдарч байхаас өөр газаргүйд хүрсэн хүнд бэрх байдлыг биеэр амсаж өнгөрүүлсэн бидэнд эдүгээ өөрийн биеэр монгол үндэстний тусгаар тогтносон улс болох БНМАУ-ыг нүдээр үзэх явдал бол туйлын их баяр баясгалантай зүйл байлаа.

Бид БНМАУ-ын талаар хязгааргүй хүсэл мөрөөдөл өвөрлөхийн зэрэгцээ сэжиглэх, эмээх сэтгэлтэйгээр очсон юм. Учир нь бидний уншсан БНМАУ-ын тухай ном зохиол бол монголын түүх болон бодит байдлыг гуйвуулж, дайсагнасан доромжлолоор дүүрэн тийм зүйл байснаас шалгалсан юм. Иймд би өөрөө Монгол улсыг өөрийн биеэр очиж үзэхсэн гэдэг хүсэлтэй байсан юм.

Миний анх удаа Монголд айлчилсан явдал бол 1967 оны наймдугаар сард байв. Энэ үед намайг хамгийн баярлуулсан зүйл гэвэл Москвад суугаа Монголын Элчин Сайдын яамнаас виз авсан тэр мөчөөс эхлэн «Монгол хэлний ертөнцөд» орсон явдал байлаа.

Монголын Элчин сайдын яамны хүмүүс болон Монгол руу нисч буй онгоцонд уулзсан хүмүүс, түүнээс хойш дөрвөн долоо хоног Монголд байх хугацаанд надад төрөлх монгол хэлнээс өөр ямар нэгэн гадаад хэл хэрэглэх шаардлага байгаагүй.

Улаанбаатарт байгаа манай нутгийн хэдэн монгол хүмүүсийн ярьсан зүйлд ч гэсэн тэд «Өвөр Монголоос анх БНМАУ-д ирээд хамгийн нэгдүгээрт «Хаана ч очсон монголоор ярихыг» дуулж байсан нь маш сайхан сэтгэгдэл төрүүлдэг байв» гэж билээ.

Иркутскээс монголын онгоцонд шилжин суухад монгол үйлчлэгч эмэгтэй монголоор ярьж байгаа нь надад уянгат хөгжим мэт сонсогдож байлаа.

Нийслэл Улаанбаатарын онгоцны буудалд гаалийн байцаан өнгөрүүлэх үед би «үнэхээр энэ улс бол биеэ даасан улс байна» гэж гүнээ биширч билээ.

Улаанбаатар бол бүхий л талаараа «орчин үеийн» хот байв. Тал нутгийн дунд монголын малчин ард түмэн орчин үеийн ийм сайхан хотыг байгуулж, эдүгээ хүртэл зонхилж ирсэн цэвэр мал аж ахуйн эдийн засгаас үйлдвэржилт өөд дэвшиж байгаа явдал бол үнэхээрийн ховор нандин замнал байжээ.

БНМАУ 1921 онд тусгаар тогтносон тухайн үед хүн ам нь зөвхөн 640 мянга байсан бол одоо нэгэнт 2 хагас дахин нэмэгдэв. Гэлээ гэхэд 1 сая 600 мянгаас хэтрээгүй. 1 сая 500 мянган хавтгай дөрвөлжин км. (Японоос 4 хагас дахин илүү) дэвсгэр нутагтай улс юм. Ийм цөөн хүн ам эзэн болж, орчин үеийн улсыг байгуулсан явдлыг төсөөлөн бодоход ч бэрхтэй байна. Хэдий тийм боловч одоо Монголыг нүдээр үзсэн хэн бүхэн «Монголчууд тал нутагтаа орчин үеийн ийм сайхан улсыг байгуулсан байна» гэж бахархал төрөхгүй байж болохгүй байхаа.

Миний хуучин мэдэж байсан Монголын нийгэм нь дундат зууны үеийн дан ганц нүүдлийн мал аж ахуйтай, үйлдвэр атугай гар үйлдвэр ч хөгжөөгүй байсан тийм нэгэн Монгол орон байсан юм. Тийм учраас монголчууд орчин үеийн нэгэн улсыг байгуулахын төлөө юм бүхнийг эхнээс нь сурахгүй бол болохгүй байжээ.

1921 онд «сургууль» гэж хэлмээр юм ганцхан байв. Гэтэл эдүгээ Монголд их сургууль 1, дээд сургууль 7 байгаагийн дээр эрдэм шинжлэл судлалын дээд байгууллага болох шинжлэх ухааны томоохон академитай болсон байна. Мөн түүнчилэн хэдэн мянган монгол хүн ЗХУ, Дорнод европын улс, сүүлийн үед Англи, Франц, Япон улсад явж суралцаж байна.

10 мянган хүн дутмаас их сургуульд 94 хүн сурч байгаа гэдэг нь хирдхийн гайхмаар дэвшилт гэж хэлэх ёстой.

Иргэдийн эрүүлийг хамгаалах талаар маш түргэн хөгжиж, 500 хүнд 1 их эмч, 100 хүнд 1 ор оногдож байгаа явдал бол хөгжилтэй улсад ч дээгүүр ордог тоо юм.

«Монголын одоогийн байдлын талаар» ярих үед энэ мэт хүнийг цочоосон тоо баримт, жишээг ард түмний амьдралын бүхий л талаас хичнээнийг ч дурдаж болох юм. Гэвч миний хувьд гэвэл монголчууд чухам хэрэг дээр ямаршуу маягаар амьдарч байгааг, юу бодож явдаг, юуг хүсч байгааг мэдэх нь чухал байсан юм.

Нийслэл Улаанбаатар хотод оршин суудаг монголчуудыг «европжсон» гэж хэлэх байх. Европ хувцас өмсөж, европ маягийн орон сууцанд сууж, европ зураг үзэж, европ хөгжим сонсож байна. Тэр талаар япончуудтай монголчууд маш төстэй гэж хэлж болмоор байна.

Японд япончууд «кимоногоо» өмсөхийн адил монголчууд монгол «дээлээ» өмсөж байна. Япончууд япон маягийн байрт дурладаг шиг монголчууд «гэр»-тээ хөл тэнүүн сууж байна. Япон дахь япон маягийн байр гэдэг нь ч гэсэн янз бүрээр өөрчлөн сайжруулж байгаачилан монгол гэрийг ч гэсэн янз бүрээр сайжруулсан байна. Эрт дээр үед гэрийн дотор «ор» гэж бараг байгаагүй. Одоо төмөр ор байхгүй гэр бараг үгүй болжээ. Дээр үед гэр дотор «тулганд» ил гал түлж байсан бол одоо зуух яндан хэрэглэдэг болж, аргалын утаанд утагдах явдал үгүй болжээ. Хотод ойрхон гэрүүдэд цахилгаантай болсноор үл барам телевизор байгаа нь бүр ч цочмоор зүйл юм. Радио, цаг, оёдлын машин зэрэг нь «ховор» зүйл огтхон ч биш болжээ. Монгол гэрийг гаднаас нь харахад бага мэт харагддаг боловч үнэн хэрэг дээр хичнээн бага гэрт ч 6 хүн элбэг унтаж болохоор зайтай. Тийм ч учраас одоо ч монголын малчид суурьшмал байшинг л ганц сайн сууц гэж санадаггүй гэж ярьцгааж байна. Эдүгээ монголын хотуудад оршин суугчид Улаанбаатарт ч бай, орон нутаг дахь хөдөө аж ахуйн нэгдлийн төвд ч бай зуны улиралд заавал «зуслан»-д гардаг. Зуслан гэдэг нь зуныг өнгөрүүлэх хөдөөлөг газар юм. 6 сарын эхнээс 8 сарын эцэс хүртэл монгол дахь хотын хүмүүсийн ихэнх нь ойр хавийн хөдөө нутагт гарч модон байшинд амьдарч тэндээс өдөр болгон хот руу ажилдаа явцгаадаг.

Бохирдсон агаартай том хотоос Монголд очсон гадаадын хүмүүс «Улаанбаатарын агаар нь цэвэр, тунгалаг сайхан» гэж гайхаж байхад монголчууд тэндээс зайлан «цэвэр агаарт гарна» гэж Улаанбаатараас зусландаа очдог ажээ. Ууланд зуны хувийн байр барих нь «хувь хүний нийгэмд эзлэх байр суурьтай холбоотой» гэж бодох хүн байж болох юм. Гэвч тийм бишээ. Зуслангийн хувийн байшинтай хүмүүс их байна. Зусланд бол монгол гэрээ хэрэглэх хүмүүс ч их байдаг. Хувийн машинтай хүмүүсийг мөн л «хувь хүний нийгэмд эзлэх байр суурьтай холбоотой» гэж бодох байх. Гэтэл тийм биш, хувьдаа машинтай хүмүүс олон боловч одоогоор хараахан нийтлэг болоогүй байна.

Монголчуудын хүнс тэжээл нь хангалттай гэдгийг монгол хүний царайг харангуут ойлгож болно. Залуучууд нь өндөр гуалиг болоод хаана ч очсон хүүхдийн эрүүл чийрэг байдал миний сэтгэлийг гүнээ хөдөлгөв. Монголчуудын хоол нь уураг тэжээлийн хувьд дэлхийд нэгдүгээрт орох бөгөөд махан хоол нь ихдэж байна гэж хэлж болмоор юм. Хотын монгол хүн одоо ногоо иддэг болсон боловч малчид нь витамин ба минералын бодисыг айраг, бяслаг зэрэг цагаан идээнээс авч байгаа бололтой.

Малчдын амьдралд ихээхэн өөрчлөлт гарчээ. Тэд Улаанбаатарын зэрэг хотын хүмүүсээс ч илүү баян амьдарч байна. Тэр нь 1950-иад оноос хойш бүх улсын малчин ардыг гурван зуун арван хэдэн «нэгдэл, ту-

хайлбал хөдөө аж ахуй, мал аж ахуйг хавсарсан хоршоололд зохион байгуулж улсаас мал аж ахуйг хөгжүүлэхэд туслан чармайсны улмаас юм. Хангайн уулархаг нутагт нэг өрх айлд 50 толгой мал, говь элсэрхэг нутгийн нэг өрхөд 75 толгой малыг хувьдаа эзэмшихийг зөвшөөрч байна. Тэр нь нэг ёсны туслах аж ахуй болж байгаа учраас «нэгдлийн гишүүдийн цалин нь бараг тэр хэвээрээ өөрт нь үлддэг» гэж хэлж болно. Жирийн малчдаас «тэгвэл таны хүсдэг юм юу байна вэ?» гэж асуухад тэдний дуртай зүйл гэвэл одоогоор гурван зүйлийг дурдаж болох юм. Тэр нь «цагаан толгойтой, пурштай ор, богино долгионы транзистор хүлээн авагч, бас нэг зүйл нь Монголд энд тэндгүй давхиж байдаг «мотоцикл» эдгээр л болно. Юу гэвэл социалист улс болохоор хүн бүр жилдээ цалинтай нэг сарын амралттай байдаг байна. Өвчин хүрвэл улсаас үнэ төлбөргүй эмчлүүлээд өгнө. Бас тэтгэвэрт гарсан цагт ч улсаас тэтгэмж авдаг учир өвчлөх буюу өтлөх цагт хэрэгтэй гэж мөнгөө хуримтлуулах явдалгүй. Тийм ч учраас Монголын малчин ард нь олсон мөнгөнийхөө ихэнхийг энэ мэт соёлын бараанд зориулж байгаа бололтой.

Залуучууд нь нийслэлийн хот маягийн амьдралд татагддаг тал байх ажээ. Тиймээс 10 жилийн өмнө мал аж ахуйд хүн хүч хүрэлцэхгүй тал байсан боловч улсаас «малчны сургууль» байгуулж, дээд боловсролтой хүний чадварыг дээшлүүлэх зэрэг арга хэмжээ авсны үрээр энэ асуудал шийдвэрлэгдсэн бололтой.

Монголын орчин үеийн уран зохиолын гол баатрын олонхи нь хотын сайхан амьдралаа орхин социалист улс орноо байгуулахын төлөө орон нутагт очиж ажиллах эрэгтэй, эмэгтэй залуусын амь бие хайрлахгүй хөдөлмөрлөх ба тэдний ирээдүйн сайн сайхныг төсөөлсөн роман байдаг. Сүүлийн үед Монголд очсон гадаадын хүн, «Монголд оросын нөлөө их байна» гэх юм уу, «монголчууд бүрмөсөн оросчлогдсон» гэх мэтээр бичиж байна. Оросын нөлөө их байх нь зүйн хэрэг гэж бодож байна. Монгол нь тусгаар тогтносон улс болж дэлхий дахины байр сууринд хүртлээ хөгжиж чадсан нь монгол-зөвлөлтийн найрамдалд тулгуурласны үр шим юм. Харин монголчууд оросчлогдоогүй байгаа нь үнэн. Орос хэл сурах явдал бол орос тэдэнд боловсрол олж авахын тулд зайлшгүй шаардлагатай байгаа хэдий боловч эцсийн эцэст монгол хэл нэгдүгээрт байдаг нь чухамхүү «Бүрэн эрхт Монгол Улс» хийгээд тэдний «харьяанд байдаггүй» монголчуудын зөрөө нь үүнд оршиж байна гэж би бодож байна.

Гадаадын зарим монголч эрдэмтэн «Монголын соёл нь мөхөж байна», «Монголжуу гэмээр юм удахгүй алга болно» гэх мэтчилэнгээр урьдчилан дүгнэн хэлэх их дуртай болжээ.

Гэтэл миний үзсэн монголчууд европ хувцас өмсч, европ маягийн байранд амьдарч үнэхээр европжиж байгаа мэтээр харагдсан боловч би орчин үеийн хэд хэдэн монголчуудын гэр орноор нь айлчилж үзсэн юм. Эрдэмтэд, албан хаагч, ажилчны гэрээр орж үзлээ. Тэнд амьдран суугч хүмүүс нь гарцаагүй монгол хүн гэдгийг гүнээ ойлгож байлаа. Тэдний хөдлөл байдал, үг ярианд хүртэл монгол хүн гэсэн өндөр бахархал үргэлж илэрч байдаг юм. Юу гэвэл «Монголын соёл» тухайлбал, «монголжуу» гэдэг нь монгол гэрт сууж, морьтой давхиж, сүм дуганд ном уншиж байх даа биш гэдгийг л мэдэхгүйгээр Монголыг зөв ойлгож хэзээ ч чадахгүй юм.

Надад төрсөн сэтгэгдэл гэвэл одоогийн монголчууд өөрийн түүхтэй болсноосоо хойш өөрсдийнхөө уламжлалт соёлыг одоогийнх шигээр хайрлаж байсан үе байгаагүй байх гэж хэлж болохоор байна. «Монголчууд, эсвэл Төв Азийн малчид залуу хойрго улс, хэрхэвч үйлдвэржиж чадахгүй», мөн «монголчууд 8 цаг хөдөлмөрлөж чадахгүй» гэж үздэг хүмүүс өнөө хүртэл байсан бөгөөд одоо ч тэгж бодож явдаг хүмүүс байсаар байна.

Монголын урьд өмнийн малчин нүүдэлчин амьдрал нь тийнхүү гадна талын үзэмжийг бий болгосноос биш, монгол хүний төрөлхийн шинж чанар нь хэрхэвч тийм биш юм. Одоо Монголд зарим хүмүүс хэт шургуу хөдөлмөрлөж байгаа мэт надад санагддаг. Би янз бүрийн ангийн хүмүүстэй уулзаж, мөн адилхан монгол хүний хувьд тэд нартай ярьж хүүрнэж байлаа.

Надад эн тэргүүнд төрсөн сэтгэгдэл гэвэл надтай уулзаж байсан хэн боловч цөм эх оронч үзэлтэй, өөрийнхөө улсын ирээдүйд маш их санаа тавьдаг хүмүүс байв. Түүнчилэн монгол залуучууд улсынхаа ирээдүйд маш их найдвар тавьж, өөрсдийнхөө ирээдүйд ч итгэл төгс байдаг юм. Энэ нь монголчууд одоогийн хөгжилд сэтгэл хангалуун байгаагийн шинж тэмдэг ажээ.

Одоо Монголд хүн амын харьцангуй цөөнөөс болж ажиллах хүч хүрэлцэхгүй асуудал байгаа юм. Монголд хүн ам улсаас тэтгэмж авдгийн үрээр одоо есөлт нь 3 хувь хүртэл нэмэгдээд байгаа боловч хүн ам уулаас цөөн байсны улмаас хүн хүч дутагдах явдал түр хугацаанд үргэлжилж магадгүй гэж бодож байна. Иймээс Монгол нь хэсэг хугацаанд монголын анд нөхдийн туслалцааг авахгүй бол болохгүй юм. Өөрийн хүчинд тулгуурлах гэдэг бол сайн л хэрэг. Гэхдээ их удаан цаг хугацаа шаардах болно. Эдүгээ монголчууд хүч бололцоогоо дайчлаад харин хүрэлцэхгүй зүйлдээ ах дүү улсын туслалцааг авч байгаа ажээ.

Миний үзсэн Монгол бол миний мэддэг байсан Монголоос тэс өөрг нүүр царайгаа цоо шинэ болгон цэцэглэж хөгжөөд шинээр улам мандан бадарч байгаа улс болсон байна. Материаллаг дэвшилтээс илүү оюун санааны дэвшил нь миний сэтгэлийг ихэд хөдөлгөдөг юм.

Орчин үеийн утга зохиолыг үндэслэн нэрд гарсан Д.Нацагдоржийн өгүүлгүүдэд «Хуучин хүү» гэдэг гол баатар байдаг юм. Хуучин хүү гэдэг бол «Хоцорсон залуу», «хуучны хэвээр байгаа этгээд» гэж ч орчуулж болох юм. Зохиолын энэ баатар бол хувьсгалын өмнөхөн үеийн монгол хүний төвийлгөсөн дүр бөгөөд дэлхийн соёлоос бүрмөсөн хоцорсон монгол хүний төрх байдлыг дүрслэн харуулсан юм. Энэ нь монголчуудын унших дуртай зохиол юм.

1976 онд Улаанбаатар хотноо болсон Олон улсын монголч эрдэмтний их хурлын үед миний сонирхлыг татсан нэг монгол эрдэмтний нэрийг «Шинэхүү» гэдэг байлаа. Тухайлбал «Хуучин хүүгийн» адилгүй «Шинэ үеийн залуу» гэдэг утгатай нэр байв. Тэр залуу эрдэмтэн сүүлийн үед Монголд олдсон эртний түрэг бичээс уншиж төвөгтэй тайлбарыг гайхмаар сайхан хийсэн нь үнэхээр эрдэм шинжилгээний илтгэл болсон юм.

Сүүлийн 11 жилийн дотор намайг Монголд 8 удаа айлчлах завшаанд уулзаж учирсан Монголын олон эрдэмтэд миний харахад цөм «Шинэ хүү», тухайлбал чухамхүү «Шинэ эрин үеийн залуус» байлаа.

Япон хэлнээс хөрвүүлсэн **Ц. Хандсүрэн**